

programme. Under ITEC assistance, a vocational training centre, named after late Prime Minister Shri Rajiv Gandhi, was established in Ulaanbaatar in 1996. The Centre currently has five faculties, namely machine shop, plumbing workshop, electrical repair shop, radio and TV workshop, and an automobile repair workshop. India has added two more faculties of gemstone cutting & polishing and computer center, and Shri K. Kant inaugurated them on 29<sup>th</sup> August 1999 at RGVTC in Ulaanbaatar.

India also provides 20 scholarship slots per annum to Mongolian students under Indo-Mongolian Cultural Exchange Programme and the General Cultural Scholarship Scheme, for pursuing undergraduate and postgraduate courses in India. In addition, two students are sent to India every year at GOI expenses for studying Hindi at the Kendriya Hindi Sansthan, Agra. An Indian Culture Center was established in Ulaanbaatar in 1992 where Hindi language and Indian music and dance are taught.

## ИХ ГЭР БҮЛ

(Монгол, Солонгос гэр бүлийн түүх-угсаатны  
зүйн харьцуулсан судалгаа)

Хүмүүнлэгийн Их Сургууль  
Соёл иргэншлийн тэнхимийн  
эрхлэгч, доктор (D.Sc) Т.Намжил

### \$1. Гэрийн үүсэл

Эрдэмтдийн судалснаар одоогоос 40000-6000 жилийн тэртээ амьдарч байсан хүмүүс малтмал сууц эрүкэ, урцыг бий болгож байжээ. /5. 155/

Шинэ чулуун зэвсгийн үед амьдарч байсан хүмүүсийн орон сууц, гэр байшин Монгол, Орос, БНАСАУ, БНСУ, Япон зэрэг Төв ба Зүүн хойт Азийн улс орнуудад судлагдажээ.

Монголын археологчид Дорнод нутгийн Тамсагбулагаас шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн сууж байсан малтмал эрүкэ сууц илрүүлэн малтсан байна.

Академич Д.Доржийн тэмдэглэсэнээр: "Эгэл тариалан эрхлэх болсон нь хүн амын зарим хэсгийг суурин амьдралд шилжихэд чухал тулхэц болжээ. Үүний тод гэрч нь Тамсагбулагт бий болсон хэдэн арван сууц бүхий тэр үеийн овгийн бүхэл бүтэн "хороолол" бөгөөд энд 5 сууц малтахад зарим сууцны урт нь 7,60 метр, өргөн нь 5,60 метр буюу нийт талбай нь 42,5 квадрат байв. /4.37/ Сууц голдоо нэлээд зайтай, баганатай байжээ. Сууцны баруун урт талд зоорийн нүхтэй.

Манжуур, Солонгосын хойг, Зүүн хойт Азид Солонгосчуудын суурьшихдаа байгуулсан малтмал сууцны үлдэгдлийг Солонгосын археологчид Пхеньян, Сөүл хотын орчим болон бусад газраас илрүүлжээ. Сууцандаа баганатай байжээ. Ойролцоогоор арваад хүн амьдардаг байсан бололтой. Урд талдаа орох үүдтэй.

Пүйе болон Когурйе нарын дунд "тазар гүн орох тутам төдийчинээ сайн сууц гэдэг байжээ." /11.82/

Японы Хоккайдо арлын Онхорманай хэмээх газраас 8,3 x 8,5 метр хэмжээтэй малтмал сууц олджээ.


Хятадаар "кан" гэж нэрлэдэг "Г" хэлбэрийн гурав юмуу таван

өрөөтэй малтмал сууцнуудыг Хятадын зүүн хойт нутгийн Ляонин, Цэилинь, Хэйлуцянь муж нутгуудаас илрүүлээд байна.

Монгол ба Зүүн хойт Азийн орны нутаг дэвсгэрээс олоод байгаа малтмал сууц хийц, хэлбэр, байгулалт, хэмжээний хувьд хоорондоо адил ойролцоо байгаа нь Төв ба Зүүн хойт Азийн орны гэрийн үүсэл хоорондоо холбоотойг харуулж байна.

Эртний хүмүүсийн сууцнаас гадна хадны зураг туг гэрийн үүслийн түүхийг тодруулах хэрэглэгдэхүүн болж байгаа юм.

Монгол Улсын Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны зурагт модтой жижиг толгойн бэлд байгаа их, бага хоёр гэр ба байшинг дүрсэлжээ.



БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Алшаа аймгийн Мөнгөн сумын нутаг дахь Мандал уулын 15 километр үргэлжилсэн хадан аманд одоогоор 6 мянга гаруй хадны зураг сүгийг хятадын археологид илрүүлээд байгаагийн дотор урц хэлбэрийн шовх оройтой хоёроос тав, зургаан давхар бүхий, дотор нь хүмүүс, сууц байгааг дүрсэлсэн зураг сонирхолыг ихэд татаж байгаа юм. Энэ зургийг Бао Хайшинь "Барилга" гэж үзжээ. /1.31/

"Барилга" зургийн төвд бусдаас нь нэг барилгыг ихэд ялгаруулан өндөр, томоор, бусад барилгуудыг түүний хоёр талд эгнээгээр тойруулан/ дүрсэлжээ.



БНХАУ. Өвөрмонгол. Мандал уулын хадны зураг

Энэ зураг ханат гэр үүсэхээс өмнөөс Урц-гэрийн үеийг харуулсан бололтой.

Оросын Холбооны улсын Сегемот, Шишкин, Манхай гэдэг газруудын хадны зурагт урт хүзүүтэй их гэрт хүмүүс суусан, гадаа нь дээрээ мухлаг бүхий тэрэг, хөллөгөнд оруулсан олон мухлаган тэрэг байгааг үзүүлсэн байна.

Эртний судлалын олдворууд нь одоогоос таван мянгаад жилийн өмнө Төв Азид хосолмол /моногам/ гэр бүл үүссэн болохыг нотлох үндэслэл болж байна.

Бидний энэхүү дүгнэлт нь эртний сурвалж бичгийн болон түүх судлаачдаас Монгол гэрийн үүслийн талаар дэвшүүлсэн санал, дүгнэлттэй үндсэндээ ойролцоо байгаа юм.

## \$2. Их гэр бүл

Гэр орны патриархал /балаг эртний/ хүй нэгдэл гэж Ф.Энгельсийн нэрлэсэн тийм хэлбэр-олон ам бүлтэй гэр бүл Монгол, Якут, Солонгос, Японд өөрөөр хэлбэл Азид дэлгэрчээ.

Монгол ба Зүүн хойт Азийн орнуудад жирийн гэр бүлээс гадна Ромын familia-д тохирох нарийн нийлмэл гэр бүл байжээ.

Ф.Энгельс гэр бүлийн үндсэн шинж нь: "гэр бүл нэгэн эцгийн хэд хэдэн үе удмыг эхнэр, хүүхэдтэй нь хамарч, тэгэхдээ бүгдээр нэгэн гэрт суудаг, тариан талбайгаа хамтран боловсруулж, нийт дундын нөөцөөс хооллож, хувцасладаг... байсанд оршино" /12.245/ гэжээ.

Эртний судлалын олдвор болон архивын материалаас үзэхэд нэгэн ам бүл нь хоёр буюу түүнээс олон үеийнхнийг хамарч байсан байна. Овгийн задралаас үүсэлтэй "айл" /Их гэр бүл-Т.Н./ нь манай тооллын XIV зууны үе хүртэл "ураг төрлийн холбоот бүлэг хүмүүс өрх гэрийн нэгдлийг илэрхийлсэн ухагдахуун байсан бололтой юм." /3.281/ Ийм байсан нь эртний уламжлал бүхий ураг төрлийн нэгдэл-Их өрх гэр /Их гэр бүл-Т.Н./-ийг илэрхийлсэнтэй холбоотой.

Монгол болон Зүүн хойт Азид гэр бүлийг янз бүрээр нэрлэсээр иржээ.

"Нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн халхчуудын дунд эртнээс... эцгийн гэрийг их гэр хэмээн хүндэтгэж" /2.266/ иржээ.

XIX-XX зууны адагт "дөрвөдийн өрх гэр нь хоёр үндсэн хэв маяг бүхий байсан"-ы нэг нь "орон гэр тусгай боловч нэг аж ахуйд

хамаарагддаг хэд хэдэн үеэс бүрдсэн ойрын садан төрлийн өрх гэр" /6.67/ байсан ажээ.

Якут /Саха/-д нэгэн гэрийн эр, эм хос ба тэдний эцэг, эх хүүхдүүдээс бүрдсэн гэр бүлийг их төлөв кэргэн гэж ярьдаг байна. Солонгосын феодалын ёст улсын үед нийгмийн үндсэн нэгж нь балар эртний /патриархал/ Их гэр бүл-Илчок хэмээх эцгийн эрхт бүлэг болдог байжээ.

Их гэрээ Монголчууд хот айлын баруун талд, Солонгост байшингийн голд барьдаг заншилтай.

Монголчууд Их гэрийн зүүн талд хүүгийн "Бага гэр"-ийг барина. "Когурйе нар хүүхний эцэг, эх их гэрийн ард хүргэн болох хархууд бага барьж өгдөг" /11.78/ байжээ.

Их гэр "гал голомт"-доо садан, төрлийнхөн сар шинийн гурванд багтаж, заавал очиж хүндэтгэл үзүүлж золгодог. Эцгийн гэрийг "Их гэр" гэж хүндэтгэдэг. Их гэр бүлд өвөг эцэг, эцгийн нөлөө их. Тэд аж ахуйг эрхлэх, үйлдвэрлэлийг зохион байгуулахад чухал үүрэг хүлээж иржээ.

Угсаатны зүйн ном зохиолуудад Их гэр бүлийг хуваагдаагүй гэр бүл гэж нэрлэдэг.

Ийм маягийн гэр бүл Дундад Азийн орнуудад ч байсаар иржээ. Их гэр бүл гэдэг юу вэ? гэвэл дорно дахины эцгийн эрхт ёсны дагуу өвөг эцэг, эмэг эх, эцэг эхтэйгээ үр хөвгүүд, ач, гуч нь нэгэн гэрт амьдарч байсныг, өөрөөр хэлбэл хоёроос дөрвөн үеийнхэн нэгэн өрх-аж ахуй болон сууж ирснийг хэлж болно.

Их гэр бүл нь үүсэхийн өмнөх үеэсээ ам бүлийн тоо нилээд цөөрч, бүтэц нь өөрчлөгдсөнөөрөө онцлог байгаа юм. Үүнийг Монгол, Солонгосын гэр бүлийн бүтцэнд гарч ирсэн өөрчлөлт нотолдог. /15/

Овгийн задралын үеэс үүссэн Их (том) гэр бүлүүд Бага гэр бүлийг бий болгожээ. Энэ нь нэг талаар гэр бүл болсон үр хүүхдүүд өвөг эмэг, эцэг эхтэйгээ хамт нэгэн гэрт амьдарцгааж ирсэнтэй, нөгөө талаар билчээрийн маллагааны болон газар тариалан, ан агнуурын ажил нь хүчээ нэгтгэж, хамтран ажиллах болсон шаардлагатай холбоотой.

Монгол болон Зүүн хойт Азийн орнуудад хүүхэд, өсвөрийн багачуудын нийгэмжих үйл явц явагддаг гол институт нь Бага гэр бүл байсаар ирсэн түүхтэй байна.

Их гэр бүлд үндэслэн Монголд хот айлын, Якут (Саха), Солонгос, Японд суурин, тосгоны систем бий болжээ.

Монголчууд эрт үеэс "Хойт айл", "Саахалт хот айл"-ын хэлбэрээр, Солонгост эрт үеэс аж ахуйн хамтын хэлбэр "ге", Чоосаны хаанчлалын үед "Хянак" хэлбэр үүсгэн амьдарцгааж иржээ.

Солонгост хамтын хөдөлмөрийн хэлбэр, харилцан туслалх заншил өргөн дэлгэрсэн нь тариачны ахуй амьдрал, аж ахуйд чухал ач холбогдолтой бөгөөд бие биедээр туслан дэмжих, хамтач үзлийн сэтгэлтэй болгон хүмүүжүүлэх чухал хүчин зүйл байлаа.

Ким Юхйог гэр бүл төвт (овгийн амьдралын орчин), амьдарч буй нутаг төвт (нутагшин суурьшсан), тав тухтай байдлыг харгалзсан (уул усны байдалд нийцүүлэн) гэх зэргээр хуваагаад, гэр бүл төвт хэлбэр нь элгэн садан гэр бүлийг төв болгосон хөршүүд гэсэн ойлголт давамгайлсан гэж үзсэн /13.83/ нь Их, ба бага гэр бүлийг хэлсэн хэрэг.

Солонгостой адил Монголчуудын Их (том) гэр ба бага гэр бүл нь садан, төрлийн холбоон дээр үндэслэгддэг.

Овгийн дотор хоньчин, адуучин, үхэрчин, тариачны гэх мэт үйлдвэр, хөдөлмөрийн өөр өөр нэгжүүд үүсэж, хоёр бага нэгж /айл/ ойролцоо буух буух суурьшиж, хөдөлмөрөө нэгтгэн хөрш суурин, тосгоны монголчуудын хэлдгээр "саахалт" айл бий болжээ.

Ийнхүү хамтрах хэлбэрт шилжиж ураг төрлөөрөө, танилаараа, эзэн албатаараа өөр хоорондоо зохицон амьдарч нэг нэгэндээ дэм болж, мал аж ахуй, газар тариалан, ан агнуур эрхлэх аргыг үүсгэсэн байна.

Өөрөөр хэлбэл элдэв халдлагаас бие биеэ хамгаалан зүд, ган тохиолдсон бэрхшээлтэй хамтран тэмцэж, илүү, дуутугаа нөхөн дүүргэдэг, зовлон жаргалаа хамтаар хуваалцаж байдаг хот айл, суурингийн хөршийн хэлбэр Монгол, Зүүн хойт Азийн оронд бий болж тогтжээ. Тэгэхлээр хот айл, суурингийн хөршийн хэлбэр гэдэг бол хамтын ажиллагааны хэлбэр байв.

Үүний хамт хот айл, суурингийн их гэр үүсчээ.

"Түүхийг сөхөн үзвэл тосгоноорхон бөөгнөрөх үйл явц их хүчтэй байлаа. Тухайлбал, нэг нутгийнхан гэхээсээ нэг тосгоныхон гэсэн ойлголт илүү хүчтэй, энэ ойлголтоос хөршийнхөн гэдэг нь илүү дотно байлаа" /13.84/.

"Хот айл", "Шинэ тосгон хөдөлгөөн", "Их, бага гэр" үүсч байх

Уед тэдгээрийг хөглөн дагуулж чадах удирдагчтай (монголчууд "өрхийн тэргүүн", "хот айлын ахлагч" гэдэг) байхыг чухалд үзсээр иржээ.

Их гэр бүл, хот айл, саахалт айл, тосгон, тосгон хөрш айлууд нь хүүхдийн хүмүүжлийн төв болсоор өнөөг хүрч иржээ.

Хот, айл, тосгоны хүүхдүүдийн хүмүүжилд оршин байгаа байгаль орчин, удам угсаа нь их нөлөөтэй ажээ.

Саахалт айл, хөрш айлууд хүүхдийн хүмүүжилд багагүй үүрэгтэй. Хүүхдэд бусдыг хүндэлж, өөрөө хүндлүүлэх аргыг хот айл, (саахалт) айлын хүмүүжил олгож байв.

Их гэр бүлүүд өөрөөсөө Бага гэр бүлийг бий болгосноос нааших хугацаанд гэр бүлийн хоёр хэлбэр байсан нь Их гэр бүл, тусгаарласан Бага гэр бүлүүд байжээ.

Монгол, Солонгос гэр бүлийн түүх, уламжлал, зан заншлын хүрээнд дараах нийтлэг таллууд байна.

- Гэр бүл уламжлалын хувьд Азийн бусад орноос Монгол, Солонгосын ард түмнүүд хоорондоо илүү төстэй байдгийн нэг суурь дэвсгэр нь Их гэр бүл юм.
- Их гэр бүлд гурваас дөрвөн үеийнхэн амьдарцгааж, эцэг өвгөд нь залгамж хойч үеэ амьдрах, аж төрөх ухаанд сургаж, өөрөөр хэлбэл Их гэр бүл нь төв болсоор ирсэн.
- Их гэрээс хүүхдүүд нь айл гэр болон тусгаарласнаар Бага гэр бүлүүд үүсч, үр хүүхдийг хүмүүжүүлэх гол үүргийг хүлээсээр байгаа.

Үүнийг онолын үүднээс авч үзвэл, Солонгосын зарим хэсгийн хүн Төв Азиас нүүдэллэн өөр өөр замаар хөгжихдөө хувируч өөрчлөгдсөн хэдий ч урьдынхаа нийтлэг талыг ямар нэгэн хэмжээгээр хадгалан үлджээ.

Бидний хийж байгаа Монгол ба Солонгосын гэр бүлийн уламжлалын харьцуулсан судалгаа нь Монгол, Солонгосын ард түмэн эрт цагаас **оюун санааны амьдралын хүрээнд** холбоотой байжээ гэсэн дүгнэлтийг дэвшүүлэхэд хүргэж байгаа юм. Энэ нь Монгол, Зүүн хойт Азийн ард түмний угсаа гарлын холбоотойг тодруулахад шууд биш ч гэсэн нэгэн хүчин зүйл болно гэдэгт найдаж байна.

Бидний хийж буй судалгаа нь Монгол, Солонгосын ард түмний гэр бүлийн түүх уламжлалын харьцуулсан Монгол дахь судлалын

ноён нурууг босгох гэж хичээсэн анхны оролдлого болох болов уу.

Монгол, Солонгосын гэр бүлийн түүхийн харьцуулсан судлалын хүрээг өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Үүний тулд яах ёстой вэ? гэсэн асуудал гарч ирж байгаа юм. Монгол, Солонгос гэр бүл судлалын асуудлаар ажиглаж

байгаа эрдэмтдийн хооронд холбоо тогтоох, харицан мэдээлэл солилцох, хамтарсан судалгаа хийх, эрдэм шинжилгээний хуралд оролцуулах улмаар хамтын бүтээл туурвих чиглэлийг баримтлан хөгжүүлэх нь зүйтэй болов уу. Бид ч энэ чиглэлээр ажиглах сонирхолтой байна. Солонгос нөхөд маань ч энэ асуудалд анхааралтай хандана гэдэгт найдаж байна.

Бид Монгол, Солонгосын гэр бүлийн хамтын судлалыг хөгжүүлэх нь зүйтэй гэж үздэг.

Эдүгээ Монгол, Орос/Буриад монгол, Якут, Тува, Хятад/Өвөр монгол, Солонгос, Японы харицлаа өргөжин гүнзгийрч байгаа нөхцөлд Монголынхтой эдгээр орнуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлалын илүү адил төстэй талыг шинжлэн гаргаж тавих нь шинжлэх ухааны болоод практикийн ач холбогдолтой асуудал болж байгааг эцэст нь тэмдэглэе.

### Genesis of the Mongolian Family education

In the issue we attempted to show basing on the archeological finds genera, the forms and specifications of the Mongolian family.

In the 3<sup>rd</sup> millennium B.C. The monogamian family was generated with in the Grand Family. About 1<sup>st</sup> millennium B.C. the Small family originated from the Grand family and then the latter began to break up since the XIII-XIV century in Mongolia and since the XIX century in Buriald Mongolia.

Nowadays everywhere in Mongolia the separate small families have been prevailing.

It is the tradition to respect the Grand family. Usually the Grand family is called the "Right family".

The Grand family is the basis of the family education system. However, the small families are separated from the Grand ones, up to

now the Grand families still have been the education centre.

### Ашигласан ном:

#### I. Монгол хэл дээр:

1. Бао Хай шинь Мандаг уулын хадны зураг. Өвөрмонголын өөртөө засах орны "Солонгос" сэтгүүл. 1997. №2.
2. БНМАУ-ын Угсаатны зүй. I. УБ., 1987.
3. Д.Гонгор Халх товчоон. II. УБ., 1978.
4. Д.Дорж Чулуун зэвсгийн үе. "Археологийн судлал" Т. XII, Ф. 1.
5. Д.Майдар, Л.Дарьсүрэн Гэр. УБ., 1974.
6. Монголын угсаатны зүй. III. УБ., 1997.
7. Т.Намжил. Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал. УБ., 1996. I дэвтэр. Редактор: А.Очир.
8. Т.Намжил. Монгол ба Зүүн хойт Азийн гэр бүл. УБ., 1996. II дэвтэр. Редактор: Академич, доктор Ч.Далай.
9. Т.Намжил, Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо. III дэвтэр. УБ., 1999. Редактор: Академич Ч.Далай.
10. Т.Намжил. Монгол гэрийн ёс уламжлал. IV дэвтэр. УБ., 1999. Редактор: А.Очир.
11. Б.Сумъяабаатар. Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал. УБ., 1975.
12. Ф.Энгельс. Өрх гэр, өмч хөрөнгө, төрийн үүсэл. К.Маркс, Ф.Энгельс. Түвээр зохиол. III. УБ., 1971.

#### II. Солонгос хэл дээр:

13. Ким Юхйог. "Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр затварт хот" II /Монгол, Солонгос хэл дээр/. Сеул. 1991.
14. Чве Чже Сок. Хангук Качок йонгу /Солонгос гэр бүлийн судалгаа/ Сеул. 1975.

#### III. Англи хэл дээр:

15. Korean Family and Kinship. Seoul 1997.
16. Korea Focus. 1997. №3, 1998. №1.

### III. ГЕОПОЛИТИК. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

#### МОНГОЛ УЛСЫН ТАДААР ЯВУУЛЖ БҮЙ БНХАУ-ЫН ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ АСУУДАА

МУИС, ОУХС-ийн багш,  
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Х.Олзэвой

1989 оны 5 дугаар сарын 16-нд Дэн Сяопин М.С.Г орбачевтой уулзаж хоёр гүрний харилцааг хэвийн, сайн хөршийн хэмжээнд эргүүлэн оруулахаар тохиролцсон билээ. Энэ уулзалтынхаа үеэр Дэн Дэлхийн II дайн дуусах дөхөхөд АНУ, Англи, ЗХУ Ялтад нууц хэлэлцээр байгуулан дайны дараахь нөлөөний хүрээгээ хуваахдаа Хятадын эрх ашигт залруулшгүй хохирол учруулсныг дурдаад энэ баримтыг тэмдэглэхдээ „зөвлөлтийн нөхдөд өнгөрсөн үеийг бид хэрхэн ойлгож байсан хийгээд өнгөрсөн хугацаанд юу бидний санаа бодлыг зовоож ирсэн бэ гэдгийг дуулгах гэсэн юм." гэж дурджээ. Тэгээд Хятад, Монголын харилцааг сөхөж, хоёр орны хооронд аль эрт хэвийн дипломат харилцаа тогтоож, янз бүрийн гэрээ хэлэлцээр байгуулж, хоёр улсын хилийг тогтоон демаркац хийсэн гэж ярьсан байдаг.<sup>1</sup>

Энэ үгэнд "алдсан" нутгийн тухай гомдол, ирээдүйд юу ч билээ гэсэн санаархал зэрэг цухалзаж байгаа нь илт байна.

Хятадын зүгээс явуулж буй энэ "алдагдсан нутаг" гэгч бодлого нь түүхийн нутгачаанд нэг ил тод болж, нэг бүдгэрч ирсэн билээ. Гэтэл монголчууд нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэн түүхийн олон зууны туршид тариалангийн Хятадаас ямагт тусгаар байсан түүх бий. Энэ байдал Хятадыг Монголчууд захиру байсан Юань гүрний үед ч (1271-1368), Хятад Монгол хоёул Манжийн ноёрхолд байсан үед ч (1644-1911) хадгалагдаж байлаа. 1921 оноос хойш ч Монгол улс тусгаар тогтносон, Хятадаас үл хамаарах орон байсныг хэлэх хэрэгтэй. Харин ЗХУ Дундад Иргэн Улсыг эрхшээлдээ авах, нөлөөндөө оруулах бодлогынхоо үүднээс Монголын араар Хятадтай тохиролцож 1924 оны хэлэлцээрээр Монгол бол Хятадын хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн боловч Хятадууд засаг захиргааны хувьд ч, цэрэг улс төрийн хувьд ч